



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 1109

Баян-Овоо

**Засаг даргын нөөц сангаас зардал
гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын Хувьсгалын 103 жилийн ой, Дадал сум байгуулагдсаны 101 жилийн ойн баяр наадмын үндэсний бөх, хурдан морь, үндэсний сурын бай шагналын өргөмжлөл, медаль, хадаг, хүндэтгэлийн гэрийн айраг болон тавгийн идээний зардлыг тус тус гаргасугай.

2. Нийт зардлын 3.034.000 (Гурван сая гучин дөрвөн мянган) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000277